1 ХОГ ХАЯГДЛАА АНГИЛАХ 10 ШАЛТГААН

Хог хаягдлаа ангилан ялгах нь байгаль орчин, эдийн засаг, нийгэмд таны төсөөлснөөс ч илүү эерэг нөлөөг бий болгодог.

01 ХОГНЫ ХЭМЖЭЭ БУУРНА

Дахин боловсруулснаар хогийн цэгт очих хог хаягдлын хэмжээ буурч хогийн цэгийн эзэлх талбайг 10-20%- far багасгах боломжтой. Энэ нь хогийн цэгээс шалтгаалан бий болох агаар, хөрс, усны бохирдлоос сэргийлнэ.

02 ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛНА

Дахин боловсруулсан материалыг ашиглах нь түүхий материалын олборлолт ба үүнтэс үүдэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасна.

03 ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭНЭ

Зөвхөн нэг кг ундааны савыг дахин боловсруулснаар 13W-ын чийдэнг 20 хоног тасралтгүй асаах эрчим хүчийг хэмнэдэг байна.

04 БАЙГАЛИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ НӨӨЦИЙГ ХЭМНЭНЭ

Байгалиас олборлож буй бүх төрлийн ашигт малтмал, газрын ба ойн баялаг, түүхий эдийг хэмнэхээс гадна ус, ургамал, амьтад, хуурай газрын ашиглалтыг бууруулдаг. Байгалийн хязгаарлагдмал нөөцийг хэмнэх нь биологийн олон янз байдлыг хамгаалж, ирээдүй хойчдоо хэрэглэх нөөцийг нь үлдээх хариуцлагатай үйлдэл юм.

05 АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛДЭГ

Дахин боловсруулах салбарт олон шинэ ажлын байрыг бий болгодог.

06 ГҮНИЙ УСЫГ ХАМГААЛДАГ

Үүсэх эцсийн хог хаягдлын хэмжээг бууруулах үчрээс хөрс цаашлаад гүний усанд нэвчих болзошгүй бохирдлоос сэргийлж чадна.

07 ОЛОН ТӨРЛИЙН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛНЭ

Хог хаягдлаас ялгарах хортой бодисууд амьсгалын зам, зүрх судас, хоол боловсруулах эрхтэн, харшил болон архаг хүүч өвчлөлүүдийг үүсгэх эрсдэлтэй байдаг. Хог хаягдал нийгмийн сэтгэл зүйд ч сөрөг нөлөөлдөг.

08 ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХУРДАСГАНА

Хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах нь тогтвортой ирээдүйг бүтээх технологийн дэвшлүүд бий болоход дэмжлэг болно.

09 НҮҮДЭЛЧДИЙН СОЁЛОО ХАДГАЛНА

Монголын нүүдэлчин соёлд байгальдаа хог хаягдалгүй, экологийн ул мөр багатай амьдарч ирсэн тухтэй. Энэ ёс заншил, уламжлал сэргээж үр хойчдоо өвлүүлэн уламжилна.

10 ӨӨРИЙН БА ӨРХИЙН ЭКОЛОГИЙН УЛ МӨРИЙГ БУУРУУЛНА

Дэлхийн нэг хүний экологийн ул мөр 1,6 га дотроо байвал дэлхийн даацын хүрээнд байна гэж тооцох боловч 2017 оны байдlaар аль хэдийн 2.8 га-д хүрсэн байна. Тэгвэл Монгол хүний экологийн ул мөр 7,3 га хэмжээтэй байна гэсэн тооцоо гарчээ.

2 ХОГООН ХЭРХЭН АНГИЛАХ ВЭ?

Дахин боловсруулах үйлдвэр нь хог хаягдлыг нарийн ангилахыг шаардаг боловч хоёрдогч түүхий эд болох боломжтой хог хаягдлыг орон сууц болон гэр хорооллын айл өрх үүсгэж буй хогны төрлүүдээсээ шалтгаалан дараах үндэсн ангиллуудаар хогийг ангилан ялгана.

ХУВАНЦАР

Бүх төрлийн ус ундааны сав, нэг удаагийн зөөлөн хуванцар халбага сэрээ, саван, шампуний сав; сүү, тараг, талх, нарийн бооны зөөлөн гялгар уут, хүнсний скоч, /PET, HDPE, PVC, LDPE, PS/, Styrofoam хөвөөнцөр

PET

- Ус ундаа
- гоо сайхны бүтээгдэхүүн
- эм, витамин
- бусад ♳PET гэсэн тэмдэгтэй хатуу хуванцар савлагааануд

HDPE

- Цэвэрлэгээний бүтээгдэхүүн
- Гоо сайхны бүтээгдэхүүн
- Бусад ♴HDPE гэсэн тэмдэгтэй хатуу хуванцар савлагааануд

LDPE

- Сүнаж ураг гялгар уутнууд
- гоо сайхны бүтээгдэхүүний ♵LDPE гэсэн тэмдэгтэй уян савлагааануд

PP

- Нэг удаагийн хоолны сав, аяга, халбага, сэрээ, соруул
- PP толгоомууд
- Тараг майонезны савлагаа

Анхаарах зүйл:

- Ус, савлагааны овор хэмжээг багасгах
- Цэвэрхэн байх.

ЦААС

Бичгийн, дэвтрийн, сонингийн болон бусад төрлийн хаягдал цаас, бор цаас, картон, ондөгний сав.

Анхаарах зүйл:

- Шохойтүй байх
- Үдэсгүй байх
- Наалттүй байх (скочгүй)

ШИЛ/ЛААЗ

Хөнгөн цагаан ундаа, пивоны лааз, бүх төрлийн цонхны шил, толь, хүнсний бүтээгдэхүүн, архи пиво, ундааны шил

Анхаарах зүйл:

- Цэвэрхэн байх
- Лаазны овор хэмжээг багасгах



ҮНС, ШААРГА

Үнсийг тусд нь хадгалснаар дахин ашиглаж, түүхий эдийн нөөц болгох боломжтой юм.



ХҮНСНИЙ ХАЯГДАЛ

Дахин боловсруулаттанд хүнсний хаягдлыг цуглуулж тээвэрлэх нь өрхийн хэмжээнд хараахан шийдэгдээгүй байгаа ч хүнсний хаягдлаараа өөрсдөө ялзмаг бордоо хийж болно.

ЖИЖИГ ЗАЙ ХУРААГУУР

Жижиг зай хураагуурыг та гэртээ цуглуулж байгаад Й-март болон CU сүлжээ дэлгүүрүүдэд аваачиж тусгай зориулалтын хогийн саванд хийгээрэй. Эдгээр нь дахин боловсруулагдахгүй ч тур хадгалах тусгай саванд байршуулах ёстой аюултай хог хаягдал юм.



ДАХИН БОЛОВСРУУЛАГДАХ БОЛОМЖГҮЙ ХОГ ХАЯГДАЛ

ЦААС Шохойтой буюу гялгар бүрэлттэй, тос болж бохирдсон цаас.

ХУВАНЦАР Манай улсад дахин боловсруулах боломжгүй хуванцар савлагааануд: зиплок уут, чихэр, чипсний уут г.м.

ШИЛ Автомашины хагарсан шил

3 АНГИЛСАН ДАХИВРААА ХААНА ТУШААХ ВЭ?

Дахин боловсруулж ашиглах тээвэрлэлтийг шийдвэрлэхийн тулд дараах алхмуудыг дагана уу.

I АЛХАМ

Юуны өмнө өрх гэрийн хэмжээнд дахивруг тусад нь хуримтлуулах хогийн сав, цаасан хайрцаг эсвэл уут шуудай бэлдэхэд хангалттай байдаг. Мөн хашаандаа эсвэл байрны гадна дахивар ангилах савыг бэлдэх шаардлагатай.

ХЭРЭВ ИЙМ САВГҮЙ БОЛ
Улаанбаатар Хотын Захиргаатайн Ажлын Албанаас хэрэгжүүлж буй
"ХОГОО АНГИЛАХ ХОДЕЛГӨӨН"
fb.com/hogooangilya
7000 2444
дээрх утас болон facebook-ээр холбогдож нийлүүлэгчдийн талаар мэдээлийг аваарай.

II АЛХАМ

Цуглуулж ангилсан дахивруудаа харанхуй өрөөнд, гадна таттан дээж эсвэл гэр, хашаандаа тусгай зай гарган овор хэмжээг нь багасгаж хадгалах нь тохиромжтой.

III АЛХАМ

Ганц өрхийн ангилсан дахиврын тээвэрлэлтийг дуудлагаар хийх боломжгүй тул хөршүүддээ эсвэл СӨХ-дөө хандан хэрхэн олон айл өрхийг хамруулж, цаашдаа нийтэд нь ачиж тээвэрлүүлэх талаар зайлшгүй зөвлөлдөөрэй.

IV АЛХАМ

Дахивраа ангилж цуглуулсны дараа дахивар тээвэрлэдэг байгууллагад хандаж, ангилсан дахивар тээвэрлэх ажлыг зохион байгуулах боломжтой эсэхийг асуугаарай.

Бүх төрлийн дахиврын овор хэмжээ хангалттай хэмжээнд хүртэл /1тн шуудай дүүрэн/ хуримтлуулсан тохиолдолд дараах явуулын дахивар нөөцийн цэгүүдэд хандаж үнэгүй тээвэрлүүлэх боломжтой. Үүнд:

Дахивар нөөцийн цэг №1
- Баянзүрх дүүрэг
- 8870 4841, 80435522, 80740022
- Сүхбаатар дүүрэг
- 80032963 80463355

Дахивар нөөцийн цэг №9
- Сонгино Хайрхан дүүрэг
- 9999 1712, 80025829

Дахивар нөөцийн цэг №82
- Чингэлтэй дүүрэг
- 8870 9002, 80348866

Дахивар нөөцийн цэг №10
- Хан-Уул дүүрэг
- 8816 5252, 80882459, 80348866

Дахивар нөөцийн цэг №59
- Налайх дүүрэг
- 8808 037, 80740022

Дахивар нөөцийн цэг
- Баянгол дүүрэг
- 8026 3300

ЭСВЭЛ

"SESL Smart Solution" ХХК
/лаз, хуванцар/
www.tmlplastic.mn
7610 7711

"Төвшин Сайхан Төв"
/Дахивар нөөцийн цэг №99/
fb.com/tuvshinsaikhancenter
9668 5858, 8813 0083

Энэ тохиолдолд тээвэрлэлтийн үнэ болох 60,000₮ тус төвөд тушаах бөгөөд овор хэмжээ хомсорхуй очилт хийх боломжтой. Энэ тохиолдолд дэргэдэх орон сууц, гэр хороолол бол дэргэдэх гудамжаа хогоо ангилахад урмалж, хамтарч дахивар цуглуулбал тээврийн үнийг хуваах төлөн хэмнэх боломжтой.

V АЛХАМ

Дахивраа тушаах өөр нэг арга бол өөрдөө ойр байрлах дахивар нөөцийн цэгт хүргэж өгөх юм. Хүрэх та өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн бол тушаасан дахиврын төлбөрийг авах болно.

Эсвэл: "Хогуй Монгол" ТББ-ын тодорхой байршилд зохион байгуулагддаг ДАЯС (Дахивар Авах Явуулын Станц) өдөрлөгөөр дахивруудаа тушаах боломжтой. ДАЯС өдөрлөгийн хугацаад хаягдал хайрцлын таваг, шил (таггүй байх ёстой), хуванцар савнуud, хөнгөн цагаан лааз зэрэг дахивруудыг хүлээн авдаг. Дарагийн өдөрлөгийн талаарх мэдээллийг https://www.facebook.com/NoPlasticMongolia -ийн 9510 4373 руу хандаж аваарай.

4 ХОГ ХАЯГДЛАА БУУРУУЛАХ БУСАД АРГУУД

5R алхмыг худалдан авалт, хэрэглээндээ нэвтрүүлэх нь өрхийн хэмжээнд хог хаягдлын хэмжээг бууруулж, нөөцөө хэмнэх маш чухал үйлдэл болдог.

ТАТГАЛЗАХ (REFUSE)

Нэг удаагийн аяга, гялгар тор гэх мэт өдөр тутамдаа хэрэглэдэг маш олон зүйлээс бид татгалзах боломжтой байдаг. Хэрэгцээгүй зүйлс худалдан авахаас зайлсхийх нь байгалийн нөөцийг хэмнэх чухал үйлдэл юм. Мөн аливаа хэрэгцээгүй болсон зүйлийг байгаль орчин бохирдуулахаас нь сэргийлж зөв зохистой устгах арга замыг төлөвлөх шаардлага тулгардаг тул худалдан авахаас өмнө татгалзах боломжтой зүйлсээс татгалзаж сурцгаая.

БАГАСГАХ (REDUCE)



Хэрэв татгалзах боломжгүй бол зөвхөн хэрэгцээтэй бараг зөв хэмжээгээр худалдаж авах нь үүсэх хог хаягдлыг хэд дахин бууруулахаас гадна маш их хэмнэлт нөөц хэмнэж байдаг. Туяайлбал анхдагч эх үүсвэрээс нь бүтээгдэхүүн аваагүй л бол бүтээгдэхүүн бүрт: олборлох, үйлдвэрлэх, тээвэрлэгдсэн материал бүтээгдэхүүнд нэмэгдэж, дахин их хэмжээний нөөц ашиглаж тээвэрлэлт хийгдэх гэх мэт маш олон үе шат дамжиж бидний гар дээр ирдэг.

ЗАСАЖ СЭЛБЭХ, СЭРГЭЭН АШИГЛАХ (REPURPOSE)

Бид ямар ч зүйлийг өөр зориулалтаар дахин ашиглаж болно. Боломжоор нь засч янзлах, сэргээн засварлах, өөр зориллоор хэрэглэж хойр дахь хэрэгцээг бий болгох боломжтой. Хогийн саванд хаядаг зүйлүүддээ бүтээлчээр хандахад л аливаа хаягдлыг тогтвортой байдлаар сэргээн ашиглахад тустай байх болно.

ДАХИН АШИГЛАХ (REUSE)

Шинээр бараа бүтээгдэхүүн худалдаж авахаас илүү өөрт байгаа зүйлсээ дахин ашиглах нь тогтвортой байдлыг хэрэгжүүлэх бас нэгэн арга юм. Олон дахин ашиглах бат бөх эдлэгэ бүхий чанартай зүйлсийг худалдан авах нь хогны хэмжээг эрс бууруулах боломжтой. Бүтээгдэхүүн худалдаж авахдаа нэг удаагийн бус харин дахин ашиглах боломжтой бүтээгдэхүүн авах тал дээр анхаарлаа хандуулаарай. Мөн дараах аргуудыг анхааралдаа аваарай:

Нэг удаагийн хуванцар, цаасан аяга, ус ундааны савны хаягдал гархаас сэргийлж өөрийн аягаа биедээ авч явж дадах. Аяга тагшаа авч явдаг нүүдэлчдийн уламжлалаа сэргээгээрэй.

Савлагааг буцаах авдаг үйлдвэрийн ус ундаа, архи пиво, сүү тараг гэх мэт хоол хүнсний зүйлс, саван шампунь, гоо сайхан ахуйн хэрэглэгдэхүүн бүтээгдэхүүнүүдийг түлхүү сонгож хэрэглэснээр савлагааг нь тушааж дахин эргэлтэнд оруулах боломжтой.

Хэрэгцээгүй болсон тавилга, хувцас, тоглоом гэх мэт зүйлсийг аль болох хог болохоос нь сэргийлдэг байх. Хэрэгтэй хүнд нь худалдах аль эсвэл хандивлах.

Цаасан амны алчуурын оронд гарын алчуурууд /нүүсны алчуурууд хэрэглэж бөөнд нь угаах цэвэрлэх.

ДАХИН БОЛОВСРУУЛАХ (RECYCLE)

Энэ нь хог болохоос сэргийлэх эцсийн арга юм. Монголчууд дахин боловсруулалт хийх тусам үйлдвэрлэлийн материалын нөөц нэмэгдэх болно. Бидний ангилсан дахин боловсруулах материалыг ашиглахын тулд үйлдвэрлэл, ажлын байр, инноваци, технологиуд шинээр үүсч гарч ирэх боломжуud бүрдэнэ.

switchasia GRANTS PROGRAMME
Европын Холбоо санхүүжүүлэв
SUSTAINABLE PLASTIC RECYCLIING IN MONGOLIA